




БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Аудитыг Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

АУДИТЫН НЭР: *Баянхонгор аймагт улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Засгийн газраас олгосон векселийн үр дүн*

АУДИТЫН КОД: УАГ-ГАГ-/2017/02-ГА-БАГ-01, УАГ-ГАГ-/2017/04-ГА-БАГ-02



Шаргалжуут тосгоны Эрүүл мэндийн төвийн гүйцэтгэгч “Алтайн газрын хүч” ХХК ажлын гүйцэтгэл илүү гаргасныг хяналгүйгээр санхүүжүүлж Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмын 3.3 дахь заалтыг зөрчсөн байна.

**Баянхонгор хот
2017.04.20**

	АГУУЛГА	
	ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	3
	Бүлэг-1. Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд эрх шилжин санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг	
	Бүлэг 2. Баянхонгор аймагт эрх шилжсэн, 2016 онд векселиэр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх	
	Бүлэг-3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд эрх шилжин санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн	
Тайланг бэлтгэсэн:	АУДИТЫН ТАЙЛАН	4
Баянхонгор аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл	
Б.Мөнхбат	АУДИТЫН ДҮН.....	4
Аудитын менежер	Бүлэг1-Зорилт Б. Зорилт Б. 2016 онд УТХО-аар шинээр хэрэгжих 6 төсөл арга хэмжээ эрх шилжиж ирснийг Худалдан авах ажиллагааны алба тендерийг шуурхай зохион байгуулсны үр дүнд дээрх ажлууд бүрэн ашиглалтад орж, улсын комисс хүлээн авсан байна.	6
Д.Цэцэгмаа		
Аудитор		
Б.Азбаяр		
Шинжээч Б.Цэрэнчимэд		
2017 оны 4 дүгээр сарын 20	Бүлэг-2-Зорилт В. Тухайн онд эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын 3584,4 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнээс 1666.6 сая төгрөгийн 7 ажлыг комисс хүлээн авч ашиглалтад оруулсан ба хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс 2062.7 сая төгрөгийн 2 ажлын явц удааширалтай, санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү авсан, зарим ажил ашиглалтын явцад чанарын шаардлага хангахгүй байгаа нь УТХО-ын үр ашиг бүрэн гараагүй байна.....	12
Тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Цахим хуудаснаас үзнэ үү:		
www.audit.bayankhongor.mn	Бүлэг 2. Баянхонгор аймагт эрх шилжсэн, 2016 онд векселиэр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх	23
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442584, 70442424 дугаарын утсаар харилцана уу.	АУДИТЫН ДҮГНЭЛТ	29
ХАЯГ: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	30
	Бүлэг 3 Баянхонгор аймгийн авто замын сангийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн	32

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	- ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ГАГ	- ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР
ГА	- ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ
УИХ	- УЛСЫН ИХ ХУРАЛ
ИТХ	- ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ЗДТГ	- ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
АЗДТГ	- АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
УТХО	- УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ТЭЗҮ	- ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ
ХХК	- ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
АТБӨЯХАТ	- АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ
ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР	
ҮХААЯ	- ҮЙЛДВЭР ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ
ЖДҮ	- ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ
МХГ	- МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
ГХБХБГ	- ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
ХБХ	- ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС
ЭМЯ	- ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭМ С	- ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
БСШУЯ	- БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ХААГ	- ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
СТСХ	- САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС
ТБОНӨХБАҮХАТХ - ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН	
ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ	

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1.Аудитын нэр: Баянхонгор аймагт улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг,

2.Аудитын код: ҮАГ-ГАГ-/2017/02-ГА-БАГ-01, ҮАГ-ГАГ-/2017/04-ГА-БАГ-02

3.Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн ҮАГ-аас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

4.Аудитын зорилтууд:

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийв.Үүнд:

1. Баянхонгор аймагт 2016 онд эрх шилжиж хэрэгжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх
2. 2016 онд векселиэр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх,
- 3.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх

5.Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг батлагдсан хуваарийн дагуу 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймагт эрх шилжсэн болон векселиэр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилт, ажлын гүйцэтгэл, болон аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалт /2016 оны замын сангийн хөрөнгө оруулалт/ тэдний гүйцэтгэсэн ажлын тайлан болон бусад холбогдох материалд тулгуурлан төсвийн ерөнхийлөн захирагч, холбогдох эрх бүхий байгууллагуудын хүрээг хамруулан гүйцэтгэв.

6. Үндсэн мэдээлэл

Баянхонгор аймагт 2016 онд Төсвийн тухай хуулиар 21257,6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл арга хэмжээнд 4471,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төсөв батлагдсанаас санхүүжилтийн эрх шилжиж ирсэн 5 төсөл арга хэмжээнд 1199,1 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

7. Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад цуглуулж судалсан баримт, материал, урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн, хийх аудитын ерөнхий эрсдэлийг **“Дунд”** гэж үнэлэв.

8. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг баримтлан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аймгийн ЗДТГ, аймгийн ГХБХБГ-ын албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга авч, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

2016 онд шинээр эхэлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хувийн хэргийг шинээр бүрдүүлж цахимд оруулан, өмнөх оноос дамжин ирсэн объектын хувьд хувийн хэрэгт нэмэлт өөрчлөлтийг хийв.

9. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
 - Векселийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам"
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам."
- Засгийн газрын 2015 оны 377 дугаар тогтоол
 - Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

I. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2016 ОНД ЭРХ ШИЛЖИН, САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр Баянхонгор аймагт эрх шилжиж 2016 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд гүйцэтгэлийн аудит хийлээ.

/Хүснэгт №-1/

Улсын төсвийн хөрөнгөөр Баянхонгор аймагт 2016 онд эрх шилжиж, санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний дэлгэрэнгүй судалгаа

Үзүүлэлт / ТАХ-ны нэр		Барилга хөрөнгө оруулалтын ажил					Их засварын ажил				Нийт дүн /сая.төг/
		Бүрэн хэрэгжиж дууссан ТАХ			Он дамжин хэрэгжиж буй, хэрэгжилт дутуу ТАХ		Бүрэн хэрэгжсэн ТАХ				
		Сумын эрүүл мэндийн төв, 10 ор /Баянхонгор, Баянбулаг сум/	Цагдаагийн байр, кабон /Баянхонгор, Жинст сум/	Цагдаагийн байр, кабон /Баянхонгор, Шаргалжуут тосгон/	Сумын эрүүл мэндийн төв, 10 ор /Баянхонгор, Шаргалжуут сум/	Соёлын төвийн барилга /Баянхонгор, Баянговь сум/	Сургуулийн дотуур байрны их засвар /Баянхонгор, Гурванбулаг сум/	Сургуулийн барилгын засвар /Баянхонгор сум, Номундалай лаборатори сургууль/	Сургуулийн барилгын засвар /Баянхонгор, Хүрээмарал сум/	Сургуулийн барилгын засвар /Баянхонгор, Баянговь сум/	
Хуулийн код		XI.Y.118	VII.111-02	VII.111-01	XIV.117	XI.2.1.15	XI.12.1-01	XI.12.1-02	XI.12.1-03	XI.12.1-04	-
Анхны төсөвт өртөг		1,112.70	80.0	80.0	1,112.70	1,105.80	50.0	60.0	70.0	213.9	3,885.10
Төсвийн тухай хуулиар	Хугацаа	2014-2016	2016-2016	2016-2016	2014-2016	2014-2016	2016-2016	2016-2016	2016-2016	2016-2016	
	Төсөвт өртөг	1,112.7	80.0	80.0	1,112.7	950.0	50.0	60.0	70.0	70.0	3,585.40
	2016 онд санхүүжих дүн	600.0	80.0	80.0	280.0	816	50.0	60.0	70.0	70.0	137160
	Векселиэр санхүүжих дүн	262.6	-	-	182.6	-	-	-	-	-	445.20
Санхүүжсэн дүн / сая		862.6	-	-	812.7	8160	48.4	54.3	64.8	70.0	1994.46
Зураг төсөв хийсэн компанийн нэр		"Хангайн Нар" ХХК	"Гоби травел" ХХК	"Гоби травел" ХХК	"Алтайн газрын хүч" ХХК	"Осиб" ХХК	"ЦЭСДА" ЗБН	"ЦЭСДА" ЗБН	"ЦЭСДА" ЗБН	"Өлзий-Иш" ХХК	-
Магадлал хийсэн төсөвт өртөг /сая төг/		1,125.69	-	-	1111.3	1105.8	-	-	-	-	3,342.76
Төндөр	Зохион байгуулсан газар	Он дамжин хэрэгжиж байгаа	Баянхонгор аймгийн ХААА	Баянхонгор аймгийн ХААА	Он дамжин хэрэгжиж байгаа	Он дамжин хэрэгжиж байгаа	Баянхонгор аймгийн ХААА	Баянхонгор аймгийн ХААА	Баянхонгор аймгийн ХААА	Баянхонгор аймгийн ХААА	-
	Шалгаруулалтын журам	-	Харьцуулалт	Харьцуулалт	-	-	Харьцуулалт	Харьцуулалт	Харьцуулалт	ээлтэй тендер	-
	Шалгарсан гүйцэтгэгчийн нэр	Баянхонгор аймгийн "Хорол багана констракшн" ХХК	Баянхонгор аймгийн "Базардарь" ХХК	Баянхонгор аймгийн "Базардарь" ХХК	Ховд аймгийн "Алтайн газрын хүч" ХХК	"Эй Ар Би Си" ХХК	Баянхонгор аймгийн "Елбата" ХХК	Баянхонгор аймгийн "Их бадарсан" ХХК	Улаанбаатар хотын "Гранд-Оре" ХХК	Баянхонгор аймгийн "Елбата" ХХК	-
гэрээ	Гэрээний эхлэх огноо	2014.10.31	2016.04.11	2016.04.11	2015.05.30	2014.06.16	2016.05.01	2016.06.02	2016.06.01	2016.07.25	-
	Гэрээний дуусах огноо	2014.12.31	2016.07.19	2016.07.19	2015.12.30	2014.12.15	2016.08.01	2016.07.20	2016.08.15	2016.09.15	-
	Сунгасан гэрээний дуусах огноо	2016.12.31	-	-	2016.12.31	2016.07.10	-	-	-	-	-
	Улсын комисс хүлээн авсан огноо	2017.03.10	2016.07.29	2016.06.24	-	-	2016.09.01	2016.09.26	2016.11.30	2016.09.23	-

2016 онд Баянхонгор аймагт улсын төсвөөс санхүүжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлаас аймгийн Засаг даргад шинээр эхлэх болон он дамжин хэрэгжиж байгаа 5 барилга байгууламжид 1121.6 сая, 4 засварын 250.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих эрхийг шилжүүлсэн байна. Үүнд:

Эрүүл мэндийн сайдын багцаас:

- Баянхонгор сумын Шаргалжуут тосгоны ЭМТ-ийн барилга /Нийт төсөвт өртөг 1112.7 сая, 2016 онд улсын төсвөөс санхүүжих дүн 280,0 сая, Векселиэр санхүүжих 182,6 сая төгрөг/
- Баянбулаг сумын ЭМТ-ийн барилга /Нийт төсөвт өртөг 1112.7 сая, 2016 онд улсын төсвөөс санхүүжих дүн 600,0 сая, Векселиэр санхүүжих 262,6 сая төгрөг /

Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас:

- Жинст сумын цагдаагийн байр, кабон /Төсөвт өртөг 80.0 сая төгрөг/
- Баянхонгор сумын Шаргалжуут тосгоны цагдаагийн байр, кабон /Төсөвт өртөг 80.0 сая төгрөг/

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас:

- Баянговь сумын соёлын төвийн барилга / Нийт төсөвт өртөг 950.0 сая, 2016 онд улсын төсвөөс санхүүжих дүн 81.6 сая төгрөг/
- Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны их засварын ажил 50.0 сая төгрөг
- Баянхонгор сумын “Номундалай” лаборатори сургуулийн барилгын засварын ажил 60.0 сая төгрөг
- Хүрээмарал сумын сургуулийн барилгын засварын ажил 70.0 сая төгрөг
- Баянговь сумын сургуулийн барилгын засвар 70.0 сая төгрөг

Зорилт Б. 2016 онд УТХО-аар шинээр хэрэгжих 6 төсөл арга хэмжээ эрх шилжиж ирснийг Худалдан авах ажиллагааны алба тендерийг шуурхай зохион байгуулсны үр дүнд дээрх ажлууд бүрэн ашиглалтад орж, улсын комисс хүлээн авсан байна.

Б.1. Аймагт эрх шилжсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны үнэлгээний хороо байгуулах, худалдан авалтын аргыг сонгох ажлууд зохих хууль, журмын дагуу ил тод, шуурхай явагдсан байна.

Баянхонгор аймагт эрх шилжин хэрэгжсэн 9 төсөл арга хэмжээнээс 6 нь тухайн онд шинээр эхэлсэн төсөл, арга хэмжээ байна. Аудитаар аймгийн Орон нутгийн өмчийн газраас тендер шалгаруулалттай холбоотой судалгааг гаргуулан авч үндсэн баримт материалтай тулган үзэв.

Аудитаар Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, хангамжийн газрын 2015.12.31- ний өдрийн 9/149Б тоот албан бичгээр Шаргалжуут, Жинст сумдад хэсгийн төлөөлөгчийн байр барих ажлыг 2016.03.01-ний дотор зохион байгуулах эрхийг Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын даргад шилжүүлжээ. Цагдаагийн газрын дарга Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны алба /тухайн үеийн/ -нд хүсэлт гарган худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Улмаар Баянхонгор аймгийн Засаг даргын 2016.01.25-ний өдрийн 43 тоот захирамжаар

Шаргалжуут 8-р багт баригдах цагдаагийн кабоны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтсийн даргаар ахлуулан 5 хүний бүрэлдэхүүнтэй, тухайн өдрийн 44 тоот захирамжаар Жинст суманд баригдах цагдаагийн кабоны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Цагдаагийн газрын даргаар ахлуулан 5 хүний бүрэлдэхүүнтэй тус тус томилсон байна.

БСШУ-ны сайдын 2016.03.14-ний өдрийн 1/2141 тоот албан бичгээр Баянхонгор сумын “Номундалай” лаборатори сургуулийн барилгын засвар, Хүрээмарал сумын сургуулийн барилгын засвар, Баянговь сумын сургуулийн барилгын засварын ажлыг, БСШУ-ны сайдын 2016.03.14-ний өдрийн 1/2143 тоот албан бичгээр Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны их засварын ажлыг аймгийн Засаг даргад эрхийг шилжүүлснээр аймгийн Худалдан авах ажиллагааны алба /тухайн үеийн/ тендер зарлажээ. Аймгийн Засаг даргын 2016.04.01-ний өдрийн 220 тоот захирамжаар Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны их засварын ажлын, 2016.04.08-ний өдрийн 217 тоот захирамжаар Хүрээмарал сумын сургуулийн барилгын засварын ажлын, 219 тоот захирамжаар “Номундалай” лаборатори сургуулийн барилгын засварын ажлын, 221 тоот захирамжаар Баянговь сумын сургуулийн барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Үнэлгээний хорооны гишүүд нь бүгд Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй, АЗ сертификаттай, шаардлага хангасан хүмүүс байна.

Тендерийн үнэлгээний хороо нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн 553.9 сая төгрөгийн өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээнээс 340.0 сая төгрөгийн өртөг бүхий 5 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 213.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар тус тус зохион байгуулсан нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын дагуу ТБОНӨХБАҮХА ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийг мөрдлөг болгон ажиллажээ.

Баянговь сумын сургуулийн барилгын засварын ажил нь 213.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ба УТХО-аар 70.0 сая төгрөг, Дэлхийн Зөн ОУБ-аас 125.9 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зураг төсвийн үнэ 16.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсан байна.

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны албанаас УТХО-аар 2016 онд шинээр зарласан тендерийн судалгаа				
	Төсөл арга, хэмжээний нэр	Хяналтын Төсөвт өртөг	Худалдан авах ажиллагаанд баримталсан журам	Хүснэгт №-2 Тендер шалгаруулалтанд зарцуулсан хугацаа
1	Цагдаагийн байр, кабон /Баянхонгор, Жинст сум/	80.0	Харьцуулалтын арга	e-procurement.mn, bayankhongor.gov.mn 2016.02.19 35
2	Цагдаагийн байр, кабон /Баянхонгор, Шаргалжуут тосгон/	80.0	Харьцуулалтын арга	e-procurement.mn, bayankhongor.gov.mn 2016.02.19 34
3	Сургуулийн дотуур байрны их засвар /Баянхонгор, Гурванбулаг сум/	50.0	Харьцуулалтын арга	e-procurement.mn, bayankhongor.gov.mn 2016.04.01 11
4	Сургуулийн барилгын засвар /Баянхонгор, Баянхонгор сум, Номундалай лаборатори сургууль/	60.0	Харьцуулалтын арга	e-procurement.mn, bayankhongor.gov.mn 2016.04.22 21
5	Сургуулийн барилгын засвар /Баянхонгор, Хүрээмарал сум/	70.0	Харьцуулалтын арга	e-procurement.mn, bayankhongor.gov.mn 2016.04.22 34
6	Сургуулийн барилгын засвар /Баянхонгор, Баянговь сум/	213.9	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	Ардчилал сонин e-procurement.mn, bayankhongor.gov.mn 2016.06.07 90
	Дүн	553.9		

Тендерийн урилгыг тухайн үед ашиглаж байсан Засгийн газрын худалдан авах ажиллагааны нэгдсэн сайт www.e-procurement.mof.gov.mn –д тухай бүр нь нийтэлсэн байна. Тендерийг шалгаруулахад дунджаар 37,5 хоног зарцуулсан ба хамгийн багадаа 11 хоног, хамгийн ихдээ 90 хоног зарцуулжээ.

Б.2. Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад нийт 11 оролцогч, харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан тендерт 3-4 оролцогч оролцсон байгаа нь өрсөлдөөнийг хязгаарлаагүй, тэгш өрсөлдөх бололцоог хангасан, худалдан авах ажиллагааны журмыг зөрчөөгүй байна.

Баянговь сумын сургуулийн барилгын засварын ажлыг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.2-т заасан “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа ажил үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэж заасны дагуу нээлттэй тендер шалгаруулалтын журмаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Тус тендерийг 2 удаа зарласан ба эхний тендер шалгаруулалтаар “Эх бүрдэн” ХХК, “Баяншарбулаг” ХХК-иуд материал ирүүлсэн боловч 2016.06.06-ны өдрийн үнэлгээний хорооны шийдвэрээр ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 30.1.1-т заасны дагуу “шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй” гэж үзэн дахин зарласан байна.

Тендерт "Баянтээх" ХХК, "Навтгар хайрхан" ХХК, "Эх бүрдэн" ХХК, "Даяар трейд" ХХК, "Гал хонгор" ХХК, "Очир заан" ХХК, "Эрч хүч хөгжил" ХХК, "Баяншарбулаг" ХХК, "Елбата" ХХК, "Халзан хайрхан" ХХК, "Үрмэсдээ" ХХК -ний материалыг 2016.07.08-ны өдөр хүлээн авч, тендерт оролцогчдыг байлцуулан

тендерийн материалыг нээж тендерийн материалыг нэг бүрчлэн үнэлж, **“Елбата” ХХК**-ний ирүүлсэн **198,2** сая төгрөгийн тендерийн материалыг шалгаруулж, үнэлгээний хорооны гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг 2016.07.08-ны өдрийн 85 тоотойр аймгийн Засаг даргад хүргүүлж, гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.1-д заасан “Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-т багтсан Жинст сумын болон Шаргалжуут 8-р багт баригдах цагдаагийн кабоны ажил, Гурванбулаг, Хүрээмарал, “Номундалай” лаборатори сургуулиудын барилгын засварын ажлыг хуульд заасны дагуу харьцуулалтын аргаар зохион байгуулжээ.

Баянхонгор сумын Шаргалжуут 8-р багт баригдсан Цагдаагийн кабоны барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Унага трейд”ХХК, “БДЗ”ХХК, “Базардарь”ХХК, “Даяар трейд” ХХК-иуд материал ирүүлснийг 2016.02.26-ний өдөр хүлээн авч, тендерт оролцогчдыг байлцуулан тендерийн материалыг нээж тендерийн материалыг нэг бүрчлэн үнэлж, **“Базардарь” ХХК**-ний ирүүлсэн **79.2** сая төгрөгийн тендерийн материалыг шалгаруулж, үнэлгээний хорооны гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг 2016.03.02-ны өдрийн № 27 тоотойр аймгийн Засаг даргад хүргүүлж, гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

Жинст суманд баригдсан Цагдаагийн кабоны барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Ноён өндөр констракшн” ХХК, “Унага трейд”ХХК, “Базардарь”ХХК, “Даяар трейд” ХХК-иуд материал ирүүлснийг 2016.02.26-ний өдөр хүлээн авч, тендерт оролцогчдыг байлцуулан тендерийн материалыг нээж тендерийн материалыг нэг бүрчлэн үнэлж, **“Базардарь” ХХК**-ний ирүүлсэн **79.6** сая төгрөгийн тендерийн материалыг шалгаруулж, үнэлгээний хорооны гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг 2016.02.29-ний өдрийн № 24 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад хүргүүлж, гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.

Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Баянговгор” хоршоо, “Халзан хайрхан”ХХК, “Елбата”ХХК-иуд материал ирүүлснийг 2016.04.08-ний өдөр хүлээн авч, тендерт оролцогчдыг байлцуулан тендерийн материалыг нээж тендерийн материалыг нэг бүрчлэн үнэлж, **“Елбата” ХХК**-ний ирүүлсэн **48.4** сая төгрөгийн тендерийн материалыг шалгаруулж, үнэлгээний хорооны гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг 2016.04.11-ний өдрийн № 17 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад хүргүүлж, гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.

Баянхонгор сумын “Номундалай” лаборатори сургуулийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “МЦ-ЭНХ” ХХК, “Их бадарсан” ХХК, “Елбата” ХХК-иуд материал ирүүлснийг 2016.04.29-ний өдөр хүлээн авч, тендерт оролцогчдыг байлцуулан тендерийн материалыг нээж тендерийн материалыг нэг бүрчлэн үнэлж, **“Их бадарсан” ХХК-ний** ирүүлсэн **54.3** сая төгрөгийн тендерийн материалыг шалгаруулж, үнэлгээний хорооны гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг 2016.04.29-ний өдрийн № 56 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад хүргүүлж, гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.


Хүрээмарал сумын сургуулийн барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Гранд-Оре” ХХК материал ирүүлсэнийг 2016.05.03-ний өдөр хүлээн авч, тендерт оролцогч компанийн төлөөллийг байлцуулан тендерийн материалыг нээж тендерийн материалыг нэг бүрчлэн үнэлж, **“Гранд-Оре” ХХК-ний** ирүүлсэн **66.0** сая төгрөгийн тендерийн материалыг “Хамгийн сайн” гэж үнэлэн, үнэлгээний хорооны гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг 2016.05.12-ний өдрийн № 59 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад хүргүүлж, гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.

Б.3 Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь ТБОНӨБАҮХА тухай хуульд заасан хугацааг баримтлан ажиллаж байгаач харьцуулалтын аргаар хийгдэж буй зураг, төсөв шаардсан, алслагдсан суманд хэрэгжих төсөл арга, хэмжээний тендерийг ажлын 5 өдрөөр сонгож байгаа нь гүйцэтгэгч ажлыг газар дээр нь үнэлэх, төсөв боловсруулах, бусад тендерийн материалыг бүрдүүлэх зэрэгт хангалттай хугацаа болж чадахгүй байна

Баянговь сумын сургуулийн барилгын засварын ажлын тендерийн урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 24.3-т заасан “Нээлттэй тендер шалгаруулалтын тухайд тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 буюу түүнээс дээш хоногоор тогтооно” гэж заасны дагуу 2016.06.07-ний өдөр www.e-procurement.mof.gov.mn сайт болон өдөр тутмын хэвлэл “Ардчилал” сонинд 2016.07.08-нд нээхээр нийтэлсэн байна. Харин харьцуулалтын аргаар зохион байгуулсан 5 төсөл, арга хэмжээний хувьд ажлын 5 өдрөөр урилгыг нийтэлсэн байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 33.3-т заасан “Энэ хуулийн 33.2.1-д заасан үнийн санал ирүүлэх хугацааг урилга илгээсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтооно” гэж заасантай нийцэж байгаа боловч алслагдсан сумын хувьд гүйцэтгэгч ажлыг газар дээр нь үнэлэх, зураг төсөв боловсруулах, бусад тендерийн материалыг бүрдүүлэх зэрэгт хангалттай хугацаа болж чадахгүй байна.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулахад зарцуулсан хугацаа /Хуанлийн хоногоор/

График № 1



ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 24.5-т “Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 45 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 6 төсөл, арга хэмжээний хувьд тендер нээснээс хойш хамгийн багадаа 10 хоног, хамгийн ихдээ 36 хоногийн дотор тендерийг нарийвчлан үнэлж, аймгийн Засаг даргад гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлэн гэрээг байгуулан ажиллажээ.

Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулсан төсөл, арга хэмжээ тус бүрээр нь хавтаст хэрэг бүрдүүлэн архивын нэгж болгон хадгалсан ба баримт бичгийг бүрэн бүрдүүлжээ.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 49.5-д заасан “Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ... тайлагнана” гэж заасны дагуу тайлан, мэдээг хугацаанд нь тайлагнаж ажилласан байна.

Б.4 Худалдан авах ажиллагааны үр дүнд нийт 25.6 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан ба санхүүжилтийн эрх шилжүүлсэн БСШУ-ны яам аймгийн Санхүү, төрийн сангийн дансаар тендерт шалгарсан өртгөөр эрх нээж санхүүжилтийг олгожээ.

Аймгийн Худалдан авах ажиллагааны алба нь эрх шилжиж ирсэн 6 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Худалдан авах

ажиллагааны үр дүнд нийт 25.6 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна. Хууль зүйн яамнаас санхүүжилтийн эрх шилжиж ирээгүй зөвхөн худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн тул тендерийн хэмнэлтийг зарцуулалтын талаар тодорхой мэдээлэл байхгүй байна. Худалдан авах ажиллагааны үр дүнд хууль, зүйн сайдын багцын 2 төсөл арга хэмжээнээс 1,26 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна.

Эрх шилжсэн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны 4 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтын үр дүнд 24.4 сая төгрөгийн хэмнэлт гарсан ба 15.7 сая төгрөг нь Дэлхийн зөн ОУБ-ын олгосон санхүүжилтээс, 8.7 сая төгрөг нь УТХО-ын санхүүжилтээс хэмнэгдсэн байна. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо тендерийн хэмнэлтийг Боловсролын яам авч үлдэн, тендерт шалгарсан төсөвт өртгөөр нь санхүүжилтийн эрхийг нээж өгсөн байна.

Б.5 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хяналтын зураг, төсөвгүй, ТЭЗҮ хийгдээгүй ажлыг зохион байгуулаагүй, техникийн тодорхойлолтыг мөрдөж ажилласан байна.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, хангамжийн газар 2015.12.31-ний өдөр Шаргалжуут тосгон, Жинст сумдад хэсгийн төлөөлөгчийн байр барих ажлыг Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын даргад төсөл сонгон шалгаруулж, хяналт тавих эрхийг, БСШУ-ны сайд 2016.03.14-ний өдөр нэр бүхий 4 төсөл арга хэмжээний төсөл сонгон шалгаруулж, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг аймгийн Засаг даргад тус бүр шилжүүлсний үр дүнд дээрх 6 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

Баянхонгор аймгийн Засаг дарга “ЦЭСДА”ЗБН-тэй гэрээ байгуулж БСШУ-ны яамнаас ирсэн 3 төсөл, арга хэмжээ болон орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгөөр хэрэгжих зарим арга хэмжээнүүдийн бэлтгэл ажлыг ханган ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 19.2-д заасан “Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Б.6 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөл арга хэмжээний зориулалтыг өөрчлөөгүй байна.

Орон нутгийн өмчийн газар /тухайн үеийн худалдан авах ажиллагааны алба/ нь худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласны үр дүнд техникийн тодорхойлолт, хяналтын зураг, төсөвт тусгагдсан ажлыг өөрчлөөгүйгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

В.Тухайн онд эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын 3584,4 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнээс 1666.6 сая төгрөгийн 7 ажлыг комисс хүлээн авч ашиглалтад оруулсан ба хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс 2062.7 сая төгрөгийн 2 ажлын явц удааширалтай, санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү авсан, зарим ажил ашиглалтын явцад чанарын шаардлага хангахгүй байгаа нь УТХО-ын үр ашиг бүрэн гараагүй байна.

В.1. Гүйцэтгэгчидтэй хийж байгаа гэрээнд “Алданги ногдуулах хэмжээ хоногт хийгдээгүй ажлын үнийн дүнгийн 0,1% байна” гэж заасан боловч гэрээний хугацаа дууссан өдрөөр захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүйгээс хийгдээгүй ажлын тоо, хэмжээ, үнийн дүнг тооцоолоогүй, гэрээг дүгнээгүй мөн захиалагчийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаагүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 40.3. дахь заалтыг зөрчиж байна.

2016 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжсэн тус аймагт эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний барилга угсралт, засварын ажлыг гүйцэтгэх гэрээг аймгийн Засаг дарга гүйцэтгэгч компаниудтай байгуулан ажилласан ба гэрээнд барилга угсралтын төсөвт өртгийн дүн, ажил гүйцэтгэх хугацаа, санхүүжилтийн хуваарь, чанарын баталгаат хугацаа, төлбөр хийх нөхцөл, хийх ажлын техникийн тодорхойлолт, захиалагч, гүйцэтгэгчийн нэр, хаяг, холбоо барих утасны дугаар, харилцах дансны дугаар зэргийг тусгаж оруулсан байна.

Гэвч боловсролын яамнаас эрх шилжиж ирсэн засварын ажлуудын гэрээний хугацаа 8-105 хоног хэтэрсэн бөгөөд гэрээнд “Алданги ногдуулах хэмжээ хоногт хийгдээгүй ажлын үнийн дүнгийн 0,1% байна” гэж заасан боловч гэрээний хугацаа дуусахад гэрээг дүгнээгүй, хийгдээгүй ажлын тоо, хэмжээ, үнийн дүнг тооцоолоогүй, хариуцлага тооцоогүй, мөн захиалагчийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаагүй байна.

Эрүүл мэндийн сайдын 2015.09.02-ний өдрийн 333 тоот тушаалаар Баянхонгор сумын Шаргалжуут тосгон, Баянбулаг сумын ЭМТ-ийн барилга угсралтын ажлын төсвийг захиран зарцуулах эрх, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

Өмнөх оноос шилжин ирсэн Баянбулаг сумын ЭМТ-ийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Хоролбагана констракшн” ХХК-тай 2015.05.30-наас 2016.12.30-ны

хооронд, Шаргалжуут тосгоны ЭМТ-ийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Алтайн газрын хүч” ХХК-тай 2016.04.25-ний өдөр Эрүүл мэнд, спортын яамны 2015.05.30-ны өдрийн БУА 01/15/01 дугаартай гэрээний хугацааг 2016.12.31-ний өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэхээр сунгасан байна.

Анх Баянбулаг сумын эрүүл мэндийн төвийн барилга 2014 оны төсөвт 600,0 сая төгрөгөөр батлагдаж, тендерийг Улаанбаатар хотын худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж “Хоролбагана констракшн” ХХКомпанитай 585.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ба гэрээнд барилгыг 14х18м-ийн хэмжээтэй, зоорьгүй, 2 давхар барилга байхаар тусгасан байдаг. Гэтэл 2015 оны Төсвийн тухай хуульд төсөвт өртөг нэмэгдэн, өмнөх онд хийгдэх барилгын хэмжээг өөрчилж 13,9 х 32м-ийн хэмжээтэй, зоорьгүй, нэг давхар барилгыг Хангайн нар ХХК-ны ХН 13/18 шифр бүхий зургаар, 1112,7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр ЭМСЯ-ны төрийн нарийн бичгийн даргатай гэрээг өөрчлөн байгуулжээ.

Мөн Шаргалжуут тосгоны ЭМТ-ийн 10 ортой эмнэлгийн барилга 2014 оны төсөвт нийт өртөг 580,0 сая төгрөгөөр тусгагдсан ба 2015 онд 1112.7 сая төгрөг болж батлагдсан байна.

Дээрх хоёр Эрүүл мэндийн төвийн барилгын ажлын зураг төсөв нь магадлалаар баталгаажаагүй, аймгийн ГХБХБГ-аас барилгын ажил эхлэх зөвшөөрөл олгоогүй байхад гүйцэтгэгч байгууллагууд барилгын ажил эхэлсэн нь Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “энэ хуулийн 13.2, 13.3-т заасан “Зураг төсөлд магадлал хийлгээгүй тохиолдолд барилгын ажил эхлэхийг хориглоно”, 16.2-т “Барилгын ажлыг зураг, төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байсныг 2016 оны УТХО-ын гүйцэтгэлийн аудитын явцад зөрчлийг арилгаж гүйцэтгэгч “Хоролбагана констракшн” ХХК нь “Хангайн нар” ХХК-ийн хийсэн нэг маягийн зурагт холболт хийлгэн мэргэшсэн төсөвчин А.Эрдэнэчимэг, тэргүүлэх төсөвчин Г.Шүрхүү нарын хийж гүйцэтгэсэн төсвөөр 2016.04.22-ний өдөр “Барилгын хөгжлийн төв”-өөр зураг, төсөлд хяналт хийлгэсэн байна.

Мөн “Алтайн газрын хүч” ХХК нь өөрийн хийсэн зургийг 2016.04.20-ний өдөр Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэсэн, “Урбан девелопмент консалтинг” ХХК-ийн тэргүүлэх төсөвчин Д.Оюунцэцэгийн гүйцэтгэж, Барилгын хөгжлийн төвөөр 2015.12.10-ний өдөр экспертээр орсон төсвөөр барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэжээ.

В.2 2016 онд санхүүжилтийн эрхийг шилжүүлсэн ЭМЯ болон БСШУ-ны яамны төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргад санхүүжилтийн эрх шилжсэн 7 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд Төсвийн тухай хуулиар 1211,6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөв батлагдсанаас аймгийн Төрийн сангийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтын дансанд нийт 1199,1 сая төгрөг ирснээс 1137.2 сая төгрөгийг гүйцэтгэгчид, 19.5 сая төгрөгийг зураг төсвийн “Осиб” ХХК-д, техник хяналтын барьцаа дансанд хяналтын болон нормчлолын сангийн 35.0 сая төгрөгийг, ГХБХБ-ын хяналтын зардлын дансанд 7.4 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

В.3 Төсөл арга хэмжээний санхүүжилтийг хугацаанд нь гүйцэтгэлээр цаг тухай бүрд нь олгосон хэдий ч Шаргалжуут тосгоны Эрүүл мэндийн төвийн ажлыг гүйцэтгэгч 216.0 сая төгрөгөөр гүйцэтгэл илүү гаргасныг хяналгүйгээр санхүүжүүлсэн байна.

2016 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 9 төсөл арга хэмжээнээс 7 ажил бүрэн хэрэгжиж, байнгын ашиглалтад өгсөн ба гүйцэтгэгч хуваарьт ажлаа хугацаандаа хийгээгүй, гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлд тухай бүр хяналт тавиагүйгээс 2 ажил хугацаандаа хэрэгжээгүй байна. Тухайлбал:

Бүрэн хэрэгжиж, ашиглалтад хүлээж авсан ажлууд:

1. “Базардарь” ХХК нь Шаргалжуут тосгоны цагдаагийн кабоны ажлыг 2016.06.24-ний №13 актаар , Жинст сумын цагдаагийн кабоны барилгын ажлыг 2016.07.29-ны №14 актаар тус тус барилга байгууламж ашиглалтад хүлээн авах комиссын актаар хүлээлгэн өгч санхүүжилтийг бүрэн авсан байна.

2. “Елбата”ХХК 48,4 сая төгрөгөөр Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны их засварын ажлыг 2016.05.01-нээс 2018.08.01-ний хооронд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 2016.09.01-ний өдрийн №09/2016 актаар барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгч санхүүжилтийг бүрэн авсан байна.

3. “Их бадарсан”ХХК 54.3 сая төгрөгөөр Номундалай сургуулийн дотор сантехникийн засварын ажлыг 2016.06.02-ноос 2018.07.20-ны хооронд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 2016.09.26-ний өдрийн №14/2016 актаар засварын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгч санхүүжилтийг бүрэн авсан байна.

4. “Гранд-Оре” ХХК 66.0 сая төгрөгөөр Хүрээмарал сумын сургуулийн хичээлийн нэгдүгээр байрны шувуун нуруу дээвэр, спорт залны хавтгай дээврийн засварын ажлыг 2016.06.01-нээс 2018.08.15-ны хооронд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 2016.11.30-ний өдрийн актаар засварын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгч санхүүжилтийн 64,8 сая төгрөгийг авсан байна. Төрийн сангийн дансаар тухайн ажлын санхүүжилт 1.2 сая төгрөгөөр дутуу ирсэн байна.

5. “Елбата” ХХК нь Баянговь сумын сургуулийн барилгын засварын ажил 213.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ба УТХО-аар 70.0 сая төгрөг, Дэлхийн Зөн ОУБ 125.9 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Зураг төсвийн үнэ 16.9 сая төгрөгийг санхүүжих нөхцөлтэй 2016.07.25-наас 2018.09.15-ны хооронд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 2016.09.23-ний өдрийн №13/2016 актаар засварын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгч УТХО-аар санхүүжих 70.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан байна.

6. Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг “Хорол багана констракшн” ХХК-тай 2014.10.31-ний өдөр байгуулсан ба барилга угсралтын ажил үргэлжлүүлэн гүйцэтгэх гэрээг 2015.05.29-ний өдөр 1112.7 сая төгрөгөөр байгуулсан. Барилга угсралтын ажлыг 2017.03.10-нд улсын комисст хүлээлгэн өгсөн ба 2016 онд УТХО-аар төрийн сангийн дансаар 600.0 сая төгрөг, векселиэр 262.6 сая төгрөгийн санхүүжилтийг авсан ба одоогийн байдлаар 250.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу байна.

Он дамжин хэрэгжих, гүйцэтгэл дутуу ажлууд:

7. “Алтайн газрын хүч” ХХК Баянхонгор сумын Шаргалжуут тосгоны Эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг 2015.01.16-ний өдөр анх байгуулж, 2015.05.30, 2016.04.25-ний өдөр үргэлжлүүлэн гүйцэтгэх гэрээнүүдийг дахин байгуулж 2016.12.31-ний өдөр ажлыг гүйцэтгэж дуусгахаар гэрээг байгуулсан.

Ажил эхэлсэнээс хойш 2015 онд 350.2 сая төгрөг, 2016 онд 329.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 2016 онд 182.6 сая төгрөгийг векселээр буюу нийт 862,6 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

“Алтайн газрын хүч” ХХК-ийн 2016.10.20-ны өдөр гаргасан ажлын гүйцэтгэлээр нийт ажлын 73% хийгдсэн гэж санхүүжилтийг авсан ба аудитын явцад объект дээр очиж ажиллахад гүйцэтгэлээр гаргасан ажлуудаас Хаалга цонхны ажил 32.1 сая, гадна дотор заслын ажил 44.1 сая, Гадна усан хангамжийн бохирын ажил 17.9 сая, Гадна дулааны ажил 49.4 сая, бохирын цооногийн ажил 28.6, гадна цахилгааны ажил 3.1 сая, Дотор цахилгааны ажил 40.4 сая төгрөгийн нийт 215.6 сая төгрөгийн ажлууд хийгдээгүй байхад гүйцэтгэлийг баталгаажуулж санхүүжилтийг УТХО-аас 630.1 сая төгрөг, векселиэр 182.6 сая төгрөгийг олгосон байна. ГХБХБГ-ын холбогдох мэргэжилтнээс ажлын гүйцэтгэлийн талаар тодруулга авахад “одоогийн байдлаар 50.0%-ийн ажил хийгдсэн” гэж үзэж байхад нийт санхүүжилтийн 73.0%-ийг авсан байгаа нь Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмын 3.3-т заасан “Захиалагч байгууллага ... ажлын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан

гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр нь тулган шалгаж, баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд гүйцэтгэлийг баталгаажуулсан буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцох, хийгээгүй 516.0 сая төгрөгийн ажлыг 2017оны 08 дугаар сарын 30-ний дотор багтаан гүйцэтгүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

8. Баянговь сумын соёлын төвийн барилгын ажлыг "Эй Ар Би Си" ХХК 2014.06.16-наас эхлэн 938.6 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа ба 2016 оны төсөвт 81.6 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилт батлагдаж аймгийн Засаг дарга гэрээний хугацааг 2016.07.10-ний өдөр хүртэл сунгаж барилгын ажлыг дуусгахаар гэрээ байгуулсан боловч одоогийн байдлаар барилгын ажлын гүйцэтгэл 95 хувьтай, ажил бүрэн хийгдэж дуусаагүй байна. Энэ талаар ГХБХБГ-ын мэргэжилтэн Н.Мөнхбаатараас тодруулахад “Үндсэн барилга угсралтын ажил дууссан, бохирын цооног хийгдсэн байгаа түүнийг холбоод, гадна талбайн тохижилтын ажил хийчихвэл ажил бүрэн дуусна” гэсэн тайлбарыг өгөв. 2016 онд батлагдсан санхүүжилтийн 19.5 сая төгрөгийг зураг төсвийн гүйцэтгэгч “Осиб”ХХК-д, 60.6 сая төгрөгийг гүйцэтгэгчид, 1.5 сая төгрөгийг техник хяналтын барьцаа дансанд тус тус шилжүүлсэн байна.

В.4 Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэл гаргасан тухай бүрд нь олгосон бөгөөд хугацаандаа хэрэгжээгүй 2 ажил нь санхүүжилтээс шалтгаалаагүй байна.

Санхүүжилтийн эрх шилжсэн ажлын санхүүжилтийг гүйцэтгэл гаргасан тухай бүрд нь олгосон ба хугацаандаа хэрэгжээгүй ажлуудын хэрэгжилт санхүүжилтээс шалтгаалаагүй байна.

В.5 Захиалагч Барилгын тухай хуулийн 7.2.6-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй, хяналт сул, гэрээг дүгнэж хариуцлага тооцоогүй, хуваарьт ажлаа хугацаандаа хийгээгүйгээс 2 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжиж хугацаа хойшилсон байна.

Аудитаар 2017.04.20-ний байдлаар 2016 онд эрх шилжсэн нийт 9 төсөл арга хэмжээнээс 7 төсөл арга хэмжээг улсын комиссоор хүлээн авч, ашиглалтад оруулж, хэвийн үйл ажиллагаа явуулж байна.

Боловсролын салбарын 4 засварын ажлын гэрээнд “алдангийг хийгдээгүй ажлыг хоног тутам 0.1 % -иар тооцно” гэж тусгасан атлаа ажил гүйцэтгэгчид бүгд гэрээний хугацаагаа 8-105 хоног хэтрүүлсэн байхад гэрээний хугацаа дуусах үед

дутуу ажлаа тодорхойлоогүйгээс алданги тооцох боломжгүй, гэрээ дүгнээгүй, гүйцэтгэгчид ямар нэгэн хариуцлага тооцоогүй байна.

Мөн Баянбулаг сумын ЭМТ-ийн барилгын ажлыг гэрээний хугацаанаас 68 хоногоор хугацаа хэтэрчээ. Барилга угсралтын ажил, их засварын ажлыг гүйцэтгэхээр захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээнд гүйцэтгэгч ажлыг ашиглалтад оруулах хугацаа, санхүүжилтийг гүйцэтгэлээр олгохыг гэрээнд тусгасан ч гэрээг дүгнээгүй, гэрээний хугацааг хэтрүүлсэн гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 7.2.6-д аймгийн Засаг дарга “барилгын зураг төсөл, барилгын ажил, барилгын материал үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас барилгын тухай хууль тогтоомж хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих” бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна.

Мөн захиалагчаас тавих хяналт хангалтгүйгээс "Алтайн газрын хүч" ХХК, "Эй Ар Би Си" ХХК-иудад бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгож Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмыг зөрчсөн асуудал гарсаар байна.

В.6 Хэрэгжиж дууссан 7 төсөл төсөл арга хэмжээг улсын комисс бүрэн хүлээж авсан бөгөөд акт гараагүй байхад ашиглалтад оруулсан зөрчилтэй асуудал гараагүй.

Харин “Алтайн газрын хүч” ХХК-ийн гүйцэтгэж байгаа 10 ортой ЭМТ-ийн гүйцэтгэл 50%, Баянговь сумын гүйцэтгэл 95%-тай байгаа бөгөөд улсын комиссын акт гараагүй объектыг ашиглаагүй байна.

В.7 2016 онд улсын төсвөөс Баянхонгор аймагт эрх шилжсэн төсөл арга хэмжээнээс 7 төсөл арга хэмжээг байнгын ашиглалтад оруулсан ба “Елбата” ХХК-ийн гүйцэтгэсэн Гурванбулаг, Баянговь сумдын сургуулийн засварын зарим ажил ашиглалтын явцад эвдрэл гарсан байна.

Аудитаар УТХО-аар эрх шилжин ирж хэрэгжсэн, ашиглалтад хүлээн авсан 7 төсөл арга хэмжээнээс “Номундалай” лаборатори сургууль, Хүрээмарал сумын сургуулийн засвар, Жинст сумын цагдаагийн кабоны ажил чанар сайн ашиглалт хэвийн үйл ажиллагаа жигдэрсэн байна.



“Базардарь” ХХК-ийн гүйцэтгэсэн Шаргалжуут тосгоны цагдаагийн кабоны ажлыг ашиглагч байгууллага чанар, ашиглалтын байдал хэвийн, гэж албан бичиг ирүүлсэн боловч аудитаар газар дээр нь очиж шалгаж үзэхэд Шаргалжуут тосгоны кабоны паркетан шал хэмжээ алдаж шахсанаас дээшээ хөндийрч, хөөсөн байдалтай, дотор тал 1 хаалга хаагдахаа больсон, цонхны ойр орчин цантаж мөстсөн байдалтай байгаа тул засвар хийлгэж хэвийн байдалд оруулах албан шаардлага өгөв.

Зураг№2




Кабоны гаднах байдал

Шал хөөсөн, цонх мөстсөн байдал

хаагдахгүй байгаа хаалга

“Елбата” ХХК-ийн гүйцэтгэсэн “Баянговь” сумын дунд сургуулийн их засварын ажил нь ашиглалтын явцад вакум цонхны завсраар салхи сийгэх, хаалганы нугас салж унах, спорт залны цонхны доод хэсгийн хана нурах, цуурах, коридорын дүүжин тааз бэхэлгээнээсээ унах зэрэг эвдрэл гэмтэл гарч байгаа, мөн Гурван булаг сумын дотуур байрны их засвар нь паркетан шалны өнгө зарим газраа хуурч, хөндийрч салсан, таазны замаск хуурч унасан, хаалгануудын нугас, бариул цоож, эвдэрсэн, цонхны гадна талын шавар ховхорч унасан, хаалга хуучин рам дээр суугдсан, амалгаа шавар нурсан, зарим тасгуудын гэрлийн унтраалга эвдэрсэн зэрэг зөрчлүүд илэрлээ. Иймд Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.23-т “Барилгын чанарын баталгаат хугацаа Барилгын тухай хуульд заасан хугацаа 3 жил байх бөгөөд энэ хугацаанд байгалийн болон давагдашгүй нөлөөнөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид эвдрэл гэмтэл гарвал гүйцэтгэгч байгууллага захиалагчийн эхний шаардлагаар үнэ төлбөргүй засварлана”, мөн гүйцэтгэгч байгууллагатай хийсэн ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлийн 10-т “чанарын баталгаат хугацаа 1095 хоног байна” гэсэн заалтуудыг үндэслэн гүйцэтгэгч байгууллагад албан тоотоор хандан эвдрэл гэмтлийг засуулах албан шаардлагыг захиалагчийн хяналт хийсэн ГХБХБГазарт хүргүүлэв.



Гурванбулаг сумын Дотуур байрны амалгаа нурсан байдал Баянговь сумын спорт залны цонхны амалгаа нурсан байдал

“Хоролбагана Констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн Баянбулаг сумын 10 ортой эмнэлгийн барилгын ажлыг аймгийн ГХБХБГ-ын дарга Т.Норовоор ахлуулсан Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах коимиссын 2017.03.10-ний өдрийн 03/2017 тоот актаар тухайн барилгыг ашиглалтад хүлээн авсан байна. Комисс хүлээн авахдаа дараах үүрэг даалгаврыг өгсөн байна.

Үүнд: хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэргэнцрийн замыг стандартын дагуу болгох, шатаах зуух өндөрлөх, эмчийн өрөөний цонхны гадна шаврыг нөхөж бөглөх, агааржуулалтын систем ажиллуулах, зарим паарны ус алдалтыг зогсоох, мооргийн өрөө, складын дотоод засварыг гүйцээх, гадаад тохижилтын ажлыг бүрэн гүйцээж хийх, хог хадгалах байр барих 8 төрлийн үүрэг даалгавар өгсөн байна.



Аудитаар газар дээр нь очиж үзэхэд дээрх үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй байна. Ашиглагч байгууллага дээрх үүрэг даалгаврыг 2017.06.25-нд хийж дуусах нэмэлт гэрээ хийгдсэн, ажил дуусмагц ашиглаж эхэлнэ гэсэн тайлбарыг 2017.04.09-ний өдрийн №42 тоот албан бичгээр ирүүлэв. Иймд улсын комиссоос өгсөн үүрэг даалгаварыг 2017.06.15-ны дотор гүйцэтгүүлж, хөрөнгийг бүрэн ашиглах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ болон Баянбулаг сумын ЭМТ-ийн дарга нарт хариуцуулан биелэлтийг хангуулахаар албан шаардлага өгөв.

Мөн Гурванбулаг сумын Сургуулийн засварын ажлын 48.4 сая төгрөг, Хүрээмарал сумын Сургуулийн засварын ажлын 64.8 сая төгрөгийн ажлыг хөрөнгийн бүртэлд сайжруулалтаар бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д заасан Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал

бүртгэнэ, 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн тул хөрөнгийг сайжруулалтаар бүртгэх албан шаардлага хүргүүлэв.

✓ **Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж Боловсролын салбар:**

Баянхонгор аймгийн боловсролын салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 265,2 сая төгрөгийн тоног төхөөрөмж хуваарилан нийлүүлсэн байна. Эдгээр хөрөнгийг БСШУЯ-ны СЭЗГазраас зарлагын паданыг бичиж Баянхонгор аймгийн сургууль, цэцэрлэгүүдийн нэрээр хуваарилсан байна. Зарим сургууль, цэцэрлэгүүд хуваарьтай тоног төхөөрөмжүүдээ БСШУЯ-аас шууд авсан байхад зарим нь аймгийн БСУГазраар дамжуулан авчээ.

БСУГазраар дамжин олгогдсон зарим сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмжийг аймгийн БСУГ-ын даргын тушаалаар дахин хуваарилж, БСШУЯ-ны хуваарьт багтаагүй цэцэрлэг, сургуульд шилжүүлэн олгосон байна. Тухайлбал: Баацагаан сумын дунд сургуульд хуваарилагдсан 1975,0 мянган төгрөгийн үнэтэй 2-р хоолны тогоог тус сумын цэцэрлэгт, 13-р цэцэрлэгт хуваарьтай 720,0 мянган төгрөгийн үнэтэй 2-р хоолны тогоог Номундалай ахлах сургуульд, Баян-Өндөр сумын цэцэрлэг, 14-р цэцэрлэг, 11-р цэцэрлэг, Шинэжинстийн цэцэрлэгт хуваарьтай хүүхдийн сандал, ширээнээс 300 ширхгийг, 13-р цэцэрлэгт 10, 6-р цэцэрлэгт 80, 3-р цэцэрлэгт 80, 1-р цэцэрлэгт 70, Баацагааны цэцэрлэгт 60 ширхгийг, 13-р цэцэрлэг /хандивын/, 5-р цэцэрлэг, 1-р цэцэрлэг, Жаргалантын цэцэрлэгүүдэд хуваарьтай багшийн ширээ, сандлуудаас 9 хосыг Баян-Өндөр сумын цэцэрлэгт-2, 3-р цэцэрлэгт-4, 6-р цэцэрлэгт-3-ыг, 13,14 болон Шинэжинстийн цэцэрлэгт хуваарьтай вандан сандлаас 14 ширхгийг 6-р цэцэрлэгт-4, 1-р цэцэрлэгт-5, Баацагаан сумын цэцэрлэгт-5-ыг, 14-р цэцэрлэгт хуваарьтай 4 ш гал тогооны шүүгээг 13-р цэцэрлэгт-1, 1-р цэцэрлэгт-3-ыг, Номгон, Эрдэнэмандал сургуульд хуваарьтай 2 ш Хөхөх принтерийг 13-р цэцэрлэгт-1, Баян-Овоо соёлын төвд 1-ыг, 14-р цэцэрлэгт хуваарьтай 5ш сургалтын хэрэглэгдэхүүнийг 13-р цэцэрлэгт, 14 болон Шинэжинст сумын цэцэрлэгт хуваарьтай 9ш тоглоомын тавиурыг 13-р цэцэрлэгт-7, 6-р цэцэрлэгт 2-ыг хуваарилан олгожээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар олгосон дээрх тоног төхөөрөмжүүдээс Баян-Овоо сумын Соёлын төв 138,0 мянган төгрөгийн үнэтэй принтер 1 ширхгийг, Номгон ахлах сургууль 1210,0 мянган төгрөгийн 10 ширхэг өлгөдөг самбар, Баянговь сумын сургууль 1128,4 мянган төгрөгийн 40 ширхэг сандал, 1485,0 мянган төгрөгийн 20 ширхэг ширээ, Баянлиг сумын сургууль 1974,7 мянган төгрөгийн 70

ширхэг сандал, 2598,7 мянган төгрөгийн 35 ширхэг ширээ, Богд сумын дунд сургууль 8901,5 мянган төгрөгийн физикийн лабораторийн тоног төхөөрөмж, Баянцагаан, Бууцагаан, Эрдэнэцогт, Баян-Өндөр, Баянговь, Гурванбулаг, Жинст сумын сургуулиуд Шинэ зуун боловсролын төслийн хүрээнд нийлүүлсэн 2805 ам.долларын үнэтэй/ $2805\$ \times 2450 \text{төг} = 6872250 \text{төг}$ / 61850,2 мянган төгрөгийн ширхэг электрон самбар, нийт 81746,7 мянган төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй, тайлан балансад тусгаагүй байгаа тул хөрөнгийг орлогод авахуулах албан шаардлага өгөв.

Эрүүл мэндийн салбар

Эрүүл мэндийн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 405,2 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээс аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийлүүлсэн 374,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг орлогод бүрэн авсан, Бууцагаан сумын ЭМТөвд нийлүүлсэн 30,7 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөс 7,4 сая төгрөгийн үнэтэй эмэгтэйчүүдийн төрөх ор ирээгүй, бусад хөрөнгийг хүлээн авч, хөрөнгийн бүртгэлд орлого авсан байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбар

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 2016 онд 3.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ширээний суурин компьютер 2 ширхэг, 3 үйлдэлт притер 1 ширхэг, 1 үйлдэлт лазер принтер 1 ширхгийг ирүүлсэн бөгөөд аудитаар техникийн үзүүлэлтийг тулган шалгахад тохирч байсан бөгөөд хөрөнгийг бүртгэсэн байна.

Засгийн газрын хэрэг эрхлэх газар

Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 ширхэг пургон автомашин болон аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн ба тухайн үеийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулснаар 3 пургон автомашиныг “Билэгт багана” ХХК 67.5 сая төгрөгөөр, тоног төхөөрөмжийг “Сүлжээний хөтөч” ХХК 32.5 сая төгрөгөөр нийлүүлснийг хүлээн авч, холбогдох газруудын хөрөнгийн бүртгэлд орлого авсан байна.

II. БАЯНХОНГОР АЙМАГТ ЭРХ ШИЛЖСЭН, 2016 ОНД ВЕКСЕЛИЭР САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ЭСЭХ

А. Баянхонгор аймагт 50876.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11963.7 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээг векселиэр санхүүжүүлэхээр баталсан ба үүний 2274.8 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ нь улсын хэмжээнд хэрэгжихээр батлагдсан байна.

Баянбулаг сумын ЭМТ болон Шаргалжуут тосгоны ЭМТ-ийн барилгын ажил 2015 оны 7 сараас эхэлсэн бөгөөд 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд заасан 2016.01.01-ний өдрийн байдлаар бодит гүйцэтгэл нь 80-аас дээш хувьтай хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг векселиэр санхүүжүүлэх гэсэн шаардлагыг хангахгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12-р сарын 03-ний өдрийн 18 тоот тогтоолд 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд заасан бодит гүйцэтгэл нь 2016.01.01-ний өдрийн байдлаар 80-аас дээш хувьтай хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг векселиэр санхүүжүүлэх шаардлага хангасан төсөл арга хэмжээг 2016 оны төсөвт тусгахаар заасан байна.

Гэтэл Баянбулаг сумын ЭМТ болон Шаргалжуут тосгоны ЭМТ-ийн барилгын ажил 2015 оны 7 сараас эхэлсэн ба 2016 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар Баянбулаг сумын ЭМТ 262.6 сая төгрөгийн буюу 23.6 хувийн гүйцэтгэлтэй, Шаргалжуут тосгоны ЭМТ 350.1 сая буюу 31.4 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь дээрх шаардлагыг хангахгүй байна.

А.2 Баянхонгор аймагт хэрэгжсэн векселиэр санхүүжүүлэх тухай ЗГ-ын тогтоолд тусгагдаж байсан төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн IV хавсралтад бүрэн тусгажээ.

Баянхонгор аймагт хэрэгжсэн дараахь 15 арга хэмжээг векселиэр санхүүжүүлэхээр Засгийн газрын тогтоол гарсан байна. Үүнд:

- Засгийн газрын 2015 оны 282 дугаар тогтоолоор 10744.7 сая төгрөгийн 6 ТАХ
- 2016 оны 72 дугаар тогтоолоор 8337.7 сая төгрөгийн 7 ТАХ
- 257 тоот тогтоолоор 31794.5 сая төгрөгийн 2 ТАХ батлагдсан нь Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн IV хавсралтад бүрэн батлагдсан байна.

А.3 Баянхонгор аймгийн Баянлиг-Шинэжинст сумын 35 кВ-ын 135 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, шугамын ажлыг эхлүүлэх ажил Монгол

Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн IV хавсралт, ЗГ-ын 2015 оны 282 дугаар тогтоолд батлагдахдаа 92.8 сая төгрөгөөр зөрүүтэй батлагдаж байжээ.

Баянхонгор аймагт хэрэгжсэн Засгийн газрын тогтоолд батлагдсан 15 төсөл арга хэмжээний дүнг Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн IV хавсралттай тулган шалгахад 92.8 сая төгрөгөөр илүү баталж байсан байна. Энэ нь Баянлиг-Шинэжинст сумын 35 кВ-ын 135 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, шугамын ажлыг эхлүүлэх ажил Засгийн газрын 2015 оны 282 дугаар тогтоолд 4373.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гэж тусгагдсан байхад 2016 оны УИХ-ын тогтоолд 4280.2 сая төгрөгөөр баталсан байна. Тухайн ажил нь Баянхонгор аймагт эрх шилжээгүй төсөл, арга хэмжээ тул тодорхой мэдээлэл авах боломжгүй байна.

А.4 Баянхонгор аймагт векселиэр санхүүжүүлэхээр батлагдсан 15 төсөл арга хэмжээ нь 2016 оны Төсвийн тухай хууль болон ЗГ-ын тогтоолд давхар тусгагдсан байна

Баянхонгор аймагт хэрэгжсэн векселиэр санхүүжихээр батлагдсан 15 төсөл арга хэмжээ нь 2015, 2016 онд батлагдсан Засгийн газрын тогтоол болон Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн IV хавсралтад давхар батлагдаж ирсэн байна.

Б. Баянхонгор аймагт векселиэр санхүүжүүлэхээр батлагдсан 6818.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 947.9 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ нь аймагт эрх шилжиж ирснээс 590.7 сая төгрөгийн 4 ТАХ-ний санхүүжилтийг векселиэр олгосон байна.

Б.1 Шаргалжуут тосгоны ЭМТ бодит гүйцэтгэл нь санхүүжилтээс дутуу байна.

Векселиэр санхүүжүүлсэн 6818.6 сая 5 төсөл арга хэмжээнээс 2735.9 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ нь ашиглалтанд орсон бөгөөд 2970.0 сая төгрөгийн өртөг бүхий Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн гүйцэтгэл 87 хувь, Шаргалжуут тосгоны ЭМТөвийн ажил ГХБХБ-ын газрын мэргэжилтний өгсөн мэдээллээр 53,0%-ийн бодит гүйцэтгэлтэй байна. /Шаргалжуут тосгоны ЭМТөвийн талаар тайлангийн 1-р бүлэгт тусгав/

Б.2 Баянхонгор аймагт хэрэгжсэн векселиэр санхүүжихээр батлагдсан ТАХ-ээс бусад төсөл, арга хэмжээг векселиэр санхүүжүүлээгүй байна

Баянхонгор аймагт хэрэгжсэн векселиэр санхүүжихээр батлагдсан ТАХ-ээс бусад төсөл, арга хэмжээг векселиэр санхүүжүүлсэн асуудал гараагүй.

Б.3 Векселиэр санхүүжүүлсэн БУА-ын гүйцэтгэл бодитой байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн паркийн 2970,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын ажлыг Бридж констракшн ХХК 2011 оноос эхлэн гүйцэтгэсэн ба 2016 оны 3-р сарын байдлаар 81,3 хувийн ажлын гүйцэтгэл гарган 2415,2 сая төгрөгийн санхүүжилт авсан, аймгийн ГХБХБГ-аас ажлын гүйцэтгэл 85,0 хувьтай гэж дүгнэсэн байна

Анх Жижиг, дунд үйлдвэрлэлийн паркийн барилгын ажлыг Хүнс, хөдөө аж ахуйн яаман дээр тендер зарлаж Бридж констракшн ХХК шалгарч улсын төсөвт 2011 онд 1370.0 сая төгрөг батлагдаж ажлыг гүйцэтгэн санхүүжилтийг бүрэн авсан, 2012 онд 699.9 сая төгрөг батлагдаж ажлыг гүйцэтгэсэн боловч 209.6 сая төгрөгийн санхүүжилт аваагүй гэсэн тайлбарыг гүйцэтгэгч компани өгсөн ба санхүүжилт орон нутгаар дамжиж олгогдоогүй байна.

Тухайн барилгын ажлыг 2011 онд эхэлсэн тухайн жилд төсөвт суусан дүнгээр тендер шалгаруулалт явуулж ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгч ирсэн ба уг барилга нь 86 м урт, 18 м өргөн 2 давхар, давхар бүрт урд эгнээнд 12 хаалгатай худалдаа үйлчилгээ үзүүлж, арын эгнээнд 8 тасалгаатай үйлдвэрлэл явуулах зориулалттай баригдсан. Барилгын зураг төсвийг Марс констракшн ХХК гүйцэтгэж, Барилгын хөгжлийн төв 2013.07.19–ны өдрийн 741/2013 тоот магадлалын ерөнхий дүгнэлтээр төсөвт өртгийг 2970,0 сая төгрөгөөр баталжээ.

2015 оны Төсвийн тухай хуулинд барилгын өмнөх оны дутуу болон үлдэгдэл ажлын санхүүжилт 1109.6 сая төгрөгийн төсөв батлагдсан боловч тодотголоор 554.8 сая төгрөг хасагдсан байна.

Гүйцэтгэгч компани аймгийн Засаг даргатай 2015.06.11-ны өдөр ажил гүйцэтгэх БХҮТП-2015/06 тоот гэрээ байгуулан, хийсэн ажлыг баталгаажуулж хүлээлгэн өгчээ.

ЖДҮ-ийг дэмжих төвийн барилгын ажил дуусаагүй, аудитын явцад ажлын гүйцэтгэлийг аймгийн ЗДТГ-ын ХОХБХ-ийн мэргэжилтэнтэй очиж үзэхэд барилгын доторхи эмульс, будаг, паркет шал, хяналтын камер, халаалтын хэрэгсэл суурилуулж холболт хийх, ариун цэврийн өрөөний дотор засал, зарим өрөөний плита шал, гадна зам талбай, ногоон байгууламж, уурын зуухны барилгын ажил эхлээгүй, тоног төхөөрөмж ирээгүй байна. Тухайн компани нь сантехникийн хэрэгсэл болон ариун цэврийн өрөөний суурилагдах тоног төхөөрөмж, паркет, плита бусад материалыг татсан агуулахад бэлэн байна. 2016 онд шинээр нэмж барилгын доторх тасалгааны хаалга, тааз, зарим өрөөний плита, барилгын доторх цахилгааны ажлыг нэмж хийсэн байна.

Уг барилгын барилга угсралтын ажил нь удааширч ажил эхэлснээс хойш 6 жил болсноос хөрөнгийн үр ашиг гараагүй байна.

Баацагаан сумын соёлын төвийн барилгын ажил нь анх 2010 онд 600.0 сая төгрөг батлагдаж 2012.09.10-ний өдөр “Идэрчандмань”ХХК-тай 675.1 сая төгрөгөөр гэрээг байгуулахдаа 600.0 сая төгрөгийг төсвийн хуульд багтсан дүнгээр, 75.1 сая төгрөгийг төсвийн тодотголд тугуулна гэж гэрээг байгуулсан байна. 2015 оны хуульд төсөвт өртөг нэмэгдэж 2015.05.28-ний өдөр гэрээний дүнг 832.0 төгрөгөөр 2015.09.21-ний өдөр ашиглалтад хүлээлгэн өгөхөөр байгуулж, 2015.11.12-ний өдөр барилгыг ашиглалтад хүлээн авсан байна. 2016 онд векселиэр 50.7 сая төгрөгөөр санхүүжихээр батлагдсаныг бүрэн авчээ. Аудитын ашиглалтын байдалтай танилцахад хэвийн байлаа.

Баянхонгор сумын Шаргалжуут тосгоны Эрүүл мэндийн төвийн барилга болон Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн барилгын талаарх тайланг 1-р бүлэгт тусгав.

Б.4 Баянхонгор аймагт эрх шилжсэн 5 төсөл арга хэмжээний векселиэр олгосон санхүүжилт, БУА-ын гэрээгээр олгох нийт санхүүжилтийн дүнгээс хэтрээгүй байна.

Эрх шилжиж ирсэн 5 төсөл, арга хэмжээнээс Баянбулаг сум болон Шаргалжуут тосгоны ЭМТөвийн 2 барилга, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажлын гэрээний санхүүжилт дутуу байгаа, Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн барилгын ажил векселиэр санхүүжилт аваагүй, харин үлдсэн 1 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт гэрээний үнийн дүнгээс хэтрээгүй байна.

Б.5. Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн векселиэр санхүүжүүлсэн 5 төсөл арга хэмжээнээс орон нутгийн 2 компанийн векселийн санхүүжилтийг тодруулсан ба харин харьяалалгүй 3 компаниас дээрх мэдээллийг тодруулах боломжгүй байна.

Баянхонгор аймагт хэрэгжсэн 5 төсөл арга хэмжээний БУА-ын үлдэгдэл гүйцэтгэлийн санхүүжилтийг векселиэр олгохдоо вексель бичих дүнг нэмэгдүүлсэн эсэхийг тодруулахад Баянбулаг сумын ЭМТ-ийн гүйцэтгэгч “Хоролбагана констракшн” ХХК векселийн хуулбарийг авчирч өгсөн, Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн гүйцэтгэгч “Хаш гоёо” ХХК-ийн менежер ирж вексел аваагүй гэсэн тайлбарыг өгсөн.Үлдсэн 3 компани Баянхонгор аймгийн харьяа компани биш бөгөөд гэрээнд заасан утас солигдсон тул холбоо барьж чадаагүй болно

Б.6 Векселийн хүүгийн тооцооллыг орон нутагт тодруулах боломжгүй байна.

Б.7 Баянхонгор аймагт эрх шилжиж, векселиэр санхүүжилт авсан 2 компанийн улсын төсвөөс 2016 онд санхүүжих гүйцэтгэлээс нь техник хяналтын зардлыг суутган тооцсон бөгөөд үлдсэн 2 компани нь ТЕЗ-тай тооцоо нийлээгүй байна.

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн гүйцэтгэгч “Хоролбагана Констракшн” ХХК нь улсын төсвөөс 600.0 сая төгрөгийн гүйцэтгэл гаргаж 2016 онд санхүүжилт авсан бөгөөд тухайн онд ТЕЗ нь 14.8 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг суутган тооцсон, Шаргалжуут тосгоны Эрүүл мэндийн төвийн гүйцэтгэгч “Алтайн газрын хүч” ХХК нь 2016 онд 280.0 сая төгрөгийн гүйцэтгэл гаргаснаас 4.4 сая төгрөгийн захиалагчийн хяналтыг суутган тооцож авч үлдсэн байна. Одоогийн байдлаар гэрээний үнийн дүнгээс “Алтайн газрын хүч” ХХК 300.0 сая төгрөгийн санхүүжилт дутуу, “Хоролбагана констракшн” ХХК 248.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу байгаа ба магадлашгүй ажлын болон норм нормативын зардлыг үлдэгдэл санхүүжилтээс тооцоо хийж авахаар байна.

Харин Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн гүйцэтгэгч “Бридж констракшн ХХК”, Баацагаан сумын соёлын төвийн гүйцэтгэгч “Идэрчандмань” ХХК-иуд ТЕЗ-тай тооцоо нийлээгүй байна.

Б.8 Засгийн Газрын өрийн бүртгэлд векселийн төлбөрийг бүрэн бүртгэж тайлагнасан эсэхийг орон нутагт тодруулах боломжгүй

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Гүйцэтгэлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. 2016 оны төсвийн тухай хуульд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт 21257,6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл арга хэмжээнд 4471,5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төсөв батлагдсан байна.

2. Баянхонгор аймгийн Засаг даргад 2016 онд өмнөх оноос он дамжин хэрэгжиж буй 3175.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, улсын төсвөөс 961.6 сая төгрөгөөр, векселиэр 445.2 сая төгрөгөөр санхүүжих 3 барилга, тухайн онд шинээр эхлэх 160.0 сая төгрөгийн өртгөөр санхүүжих хоёр цагдаагийн кабоны барилга, 250.0 сая төгрөгөөр санхүүжих 4 их засварын ажлын эрх шилжиж ирсэн байна.

3. Худалдан авах ажиллагааны алба 2016 онд шинээр эхлэх, эрх шилжиж ирсэн 6 төсөл, арга хэмжээний тендерийг зохих журмын дагуу шуурхай зохион байгуулсан ба харин харьцуулалтын аргаар хийгдэж буй зураг, төсөв шаардсан, алслагдсан суманд хэрэгжих төсөл арга, хэмжээний тендерийг ажлын 5 өдрөөр сонгож байгаа нь гүйцэтгэгч ажлыг газар дээр нь үнэлэх, төсөв боловсруулах, бусад тендерийн материалыг бүрдүүлэх зэрэгт хангалттай хугацаа болж чадахгүй байна.

4. Тухайн онд эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын 3584,4 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнээс 1666.6 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг улсын комисс хүлээн авсан бөгөөд Барилгын тухай хуулийн 7.2.6-д заасны дагуу хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээг дүгнэж хариуцлага тооцоогүйгээс 2062.7 сая төгрөгийн 2 ажил бүрэн хэрэгжээгүй, санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгожээ.

5. Шинээр ашиглалтад орсон Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн нэмэлт ажил дутуу, Баянговь, Гурванбулаг сумын сургуулийн засварын ажил ашиглалтын явцад чанарын шаардлага хангахгүй байгаа нь УТХО-ын үр ашиг бүрэн гараагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

2017.04.19

Баянхонгор хот

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Баянхонгор аймагт улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорхи албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

НЭГ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.БАТЖАРГАЛД

1. Гүйцэтгэгчидтэй хийж байгаа гэрээг дүгнэж, гэрээнд захиалагчийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаж ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 40.3. дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.3 дахь заалтыг зөрчиж, аймгийн ГХБХБГазар, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга нар хийгдээгүй ажлын гүйцэтгэлийг баталгаажуулан, санхүүжилт олгосон тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох, цаашид зөрчлийг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллах.

3. Улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээн авсан барилгын ашиглалтын байдалд хяналт тавьж, чанарын шаардлага хангахгүй байгаа төсөл, арга хэмжээний зөрчлийг тухай бүр нь арилгуулж, Барилгын тухай хуулийн 12.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ХОЁР. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ

1. Харьцуулалтын аргаар хийгдэж буй зураг, төсөв шаардсан, алслагдсан сумын хувьд гүйцэтгэгчид ажлыг газар дээр нь үнэлэх, төсөв боловсруулах, бусад тендерийн материалыг бүрдүүлэх хугацааг тооцоолж худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх.

2. Ашиглалтад орсон төсөл, арга хэмжээний үр дүнг хянан үзэж, чанаргүй ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийг дахин худалдан авах ажиллагаанд оролцуулахгүй байх.

ГУРАВ. АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ

1. Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ын 3.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Барилгын баталгаат хугацаанд хүлээж авсан барилгын ашиглалтын байдалд дахин хяналт хийж, Баянговь, Гурванбулаг сумын сургуулийн чанаргүй хийсэн ажлыг 2017.06.15-ний дотор зөрчлийг арилгах.

Гүйцэтгэлийн аудитаар тогтоосон акт, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2017 оны 09-р сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг мэдэгдье.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ